

Батлав.

БОАЖЯ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЯГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“ПЛАСТИК САКСЕС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ:



Я.Золзаяа

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ 20-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭД
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН” ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-н мэргэжилтэн

.....

/

/

Боловсруулсан:

“ПЛАСТИК САКСЕС” ХХК-н Биологич

С.Мөнгөнбагана

/

/

Улаанбаатар хот, 2023 он

Шүүмжийн дагуу зассан тухай

1. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс тусад нь салгаж төлөвлөх, (БОАЖСайдын 2019 оны А-618 дугаар журмын дагуу), тусад нь Тэрбум модны хүрээнд хаана хэдэн төгрөгөөр хэдэн ямар мод тарих гэх мэт тодорхой хүснэгтлэж төлөвлөх
 - *22-р хуудсанд Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэсэгт төлөвлөгөөг дэлгэрүүлэв.*
2. 22 хуудасны тайлагнах хуваарийг засах, НБОГ-т тайланг дүгнүүлэх гэж оруулах, журмын хугацааг оруулах
 - *21-р хуудас буюу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэсэгт оруулсан.*
3. Төслийн ариун цэврийн байгууламжийн мэдээллийг ирүүлэх, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай бол зургийг оруулах, хэрэв байхгүй бол 2023 онд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болно гэж тусгах
 - *14-р хуудсанд ариун цэврийн байгууламжийн танилцуулгыг оруулав.*

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн нэр	4
1.2. Төслийн зорилго:	4
1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
1.4. Төслийн байршил	4
1.5. Төслийн хүчин чадал	5
1.6. Түүхий эд, бүтээгдэхүүн	5
1.7. Тоног төхөөрөмж	6
1.8. Технологийн процесс	9
1.9. Бэлэн бүтээгдэхүүн	11
1.10. Үйлдвэрийн усан хангамж	12
1.11. Уурхайн цахилгаан хангамж	13
1.12. Дулаан хангамж	13
1.13. Завсрын бүтээгдэхүүн, Хог хаягдлын тооцоо	13
1.14. Ариун цэврийн байгууламж	14
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨД, ҮНЭЛГЭЭ	15
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ДОЛОО. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
НАЙМ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ...	23
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	23
АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24

Зургын жагсаалт

Зураг 2. Төслийн байршил	5
Зураг 3. Багцын уут үлээх төхөөрөмж SJ-50FM1300	6
Зураг 4. Бутлагч.....	7
Зураг 5 Ус шавхан цацагч	7
Зураг 6 Мөхлөг болгогч /бутлагдсан дахивар бүтээгдэхүүнийг хайлуулах үндсэн төхөөрөмж/.....	7
Зураг 7 Хайлуулж уртасгасан хайлмагыг хөргөх, мөхлөг болгох шугам.....	8
Зураг 8 Бүрэн автомат хогны уут наах машин	8
Зураг 9 Бүрэн автомат хогны уут наах машин	9
Зураг 10. Багцын уутын тоног төхөөрөмжүүд.....	11
Зураг 11 Хогны уут болон багцлагч хальс.....	12

Зураг 12 Бэлэн бүтээгдэхүүн.....	12
Зураг 13. Хорт хий, утааны нөлөөллийн цар хүрээ	16

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Төслийн талбайн координат.....	4
Хүснэгт 3. Түүхий эд.....	5
Хүснэгт 4. Технологийн эхний үе шат.....	9
Хүснэгт 5. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа	15
Хүснэгт 4. БОМТ-ийн зардлын задаргаа	17
Хүснэгт 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Хоёрдогч түүхий эд дахин боловсруулах” үйлдвэр

1.2. Төслийн зорилго:

Хаягдал түүхий эдийг боловсруулан түүхий эд гарган авах, уг түүхий эдээс нэмүү өртөгтэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр шинээр болгох, хог хаягдлыг багасгах.

1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

“Пластик Саксес” ХХК-н үйлдвэр нь үндсэн түүхий эд болох цэвэр ус, ундааны хуванцар сав, шуудай болон гялгар уутыг хүлээн авч ангилан ялгах, угаах, нунтаглаж жижиглэх, хэвлэж гаргах үндсэн шат дамжлагатай ажиллаж байна. Ангилан ялгах, угаах, нунтаглаж жижиглэх, хэвлэж гаргах ажлуудыг үйлдвэрийн орчинд буюу битүү орчинд хийж гүйцэтгэдэг. Хог хаягдлыг угааж түүхий эдэд бэлтгэхэд сард 5 тонн ус ашигладаг. Технологийн шат дамжлагад ямар нэг нэмэлт химийн бодис ашиглахгүй. Үйлдвэрийн халаалтыг тоног төхөөрөмжийн тэнн халаагуураар халаах боломжтой байдаг тул уурын зуухны галлагаа өвлийн цагт бага байдаг. Ажиллагсдын тоо: 25. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг мөн 2020 онд батлуулж 2021 оноос албан ёсоор эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Пластик Саксес” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011556026
Регистрийн дугаар	5988268
Хаяг	УБ хотын БГД-ийн 14-р хороо, 3-р хороолол, 13в, 89 тоот
Утас	99148720

1.4. Төслийн байршил

УБ хотын СХД-ийн 20-р хороо, Толгойт 18104, Хүнсчдийн гудамж 19 тоот хаалга

Хүснэгт 2. Төслийн талбайн координат

№	Уртраг	Өргөрөг
1	106°46'6.97"	47°54'36.71"
2	106°46'6.71"E	47°54'38.22"N
3	106°46'12.02"E	47°54'38.76"N
4	106°46'12.08"E	47°54'37.68"N
5	106°46'11.68"E	47°54'37.20"N



Зураг 1. Төслийн байршил



1.5. Төслийн хүчин чадал






Үйлдвэр нь өдөрт ойролцоогоор 1 тн, сард 25 тн хоёрдогч түүхий эдийг боловруулах хүчин чадалтай.

1.6. Түүхий эд, бүтээгдэхүүн

Үйлдвэрийн гол түүхий эд болох үндсэн материал нь байгаль орчин эргэлтэнд ордоггүй буюу хор хөнөөлтэй бүлэгт орсон түүхий эдүүд болно. Энэхүү бүтээгдэхүүн нь байгаль орчинд ил задгай хаягдсанаараа хог хаягдлын үндсэн масс хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байна. Иймд эдгээр цэвэр ус, ундааны хуванцар сав, шуудай болон гялгар уутыг дахин боловсруулалтанд оруулж түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн хийх цаашлаад төв суурин газарт үүссэн хог хаягдлыг багасгах, уул уурхайн хог хаягдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Дараах төрлийн хог хаягдлын эх үүсвэрүүдийг цуглуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үүнд:

Хүснэгт 3. Түүхий эд

Код	Шинжлэх ухааны нэршил тэмдэглэгээ	Эд зүйлс
 PETE	PET ба PETE /polyethylene terephthalate/	/polyethylene terephthalate/ Уух ундаа болон пивоны уян хатан чанартай хуванцар сав, ургамлын тосны сав, газрын самарны савлагаа, жимсны чанамалын савлагаа гэх мэт.
 HDPE	HDPE ба PE-HD /high density polyethylene/	/high density polyethylene/ Хүнсний бүтээгдэхүүн болон гоо сайхан, угаалгын нунтага, шампунд тусгайлан зориулсан савлагаа, жимсний шүүсний болон сүүний

		савлагаа, барилгын ороох боох материал, моторын тосны сав, хүсний тор, багцлагч гэх мэт.
	PVC ба V /polyvinyl chloride/	Хүсний бус багцлагч, цонх цэвэрлэгч болон гоо сайхны савлагаа, цонх, эмнэлгийн тоног төхөөрөмж,
	LDPE ба PE-LD /low density polyethylene/	Хөлдөөсөн хүсний бүтээгдэхүүний савлагаа, хуурай цэвэрлэгээний уут, хувцас, хивс, хивсэнцэр, тоноглол, хуванцар шүүшигч
	PP /polypropylene/	Нэг удаагын хэрэглээний аяга, тарагны сав, гал тогооны сав суулга, богино долгионы зуухны сав суулга, хавтан, сүүний савлагаа, эмнэлгийн савлагаа
	PS /polystyrene/	Өндөгний савлагаа, нэг удаагын савлагаа, нэг удаагын халбага, сэрээ
	Other ба O	Дээрх ангилалд ороогүй зүйлс хамаарна.

Түүхий эдийн дийлэх хувийг уул уурхайд ашиглагдсан даацийн шуудай эзэлж байна. 2018 оноос Монгол улсын тэргүүлэх уул уурхайн компаний нэг болох “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ий уул уурхайн баяжмал боловсруулах үндсэн түүхий эд болох ammonium nitrate-ийн МАХАМбрендийн баяжмалын уутыг “ДӨРВӨЛЖИН ЭРДЭНЭ” ХХК-тай хийсэн гэрээний /гэрээг хавсралтаар оруулсан болно/ дагуу авч уул уурхайд хоргүй байдлаар боловсруулан шуудайны үндсэн түүхий эд болох PP-/polypropylene/-г гарган аваад байна.

Багцын уутны үндсэн түүхий эд болох LLDF-г дотоодын зах зээл дээрх бусад дахивар бүтээгдэхүүний үйлдвэрээс 1кг-г 1500 төгрөгөөр худалдан авдаг болно. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас дүгнэн үзэхэд сард дунджаар 15 тн түүхий эд худалдан авдаг.

1.7. Тоног төхөөрөмж

2009 онд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн 380В-д ажилладаг, уур, ус хэрэглэдэггүй багцын уут үйлдвэрлэх SJ-40FM1000 загварын иж бүрэн нэг шугам тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна /техникийн үзүүлэлтийг 11-р хүснэгтэд үзүүлэв/. Үйл ажиллагааны цаашдын шаардлага, эрэлт хэрэгцээтэй уялдуулан 2011 онд үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэн 2010 онд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн багцын уутыг үндсэн хоёр сектороор ороох үйлдэлтэй SJ-50FM1300 загварын сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглаж байна /Зураг /.



Зураг 2. Багцын уут үлээх төхөөрөмж SJ-50FM1300

Анхны дахивар бүтээгдэхүүнийг бутлан ажилд бэлэн болгох дараах бутлагч төхөөрөмжийг ашиглана.



Зураг 3. Бутлагч

Бутлагдсан дахивар бүтээгдэхүүний усыг шавхан хатаагч төхөөрөмжинд оруулна



Зураг 4 Ус шавхан цацагч



Зураг 5 Мөхлөг болгогч /бутлагдсан дахивар бүтээгдэхүүнийг хайлуулах үндсэн төхөөрөмж/



Зураг 6 Хайлуулж уртасгасан хайлмагыг хөргөх, мөхлөг болгох шугам

2019 оны 11 сард үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах үүднээс БНХАУ-ын Wenzhou мужийн улсын үйлдвэрээс дараах тоног төхөөрөмжүүдийг гэрээний дагуу худалдан /хүснэгт. 3/, /зураг. / авсан бөгөөд тухайн мужийн шуудайны үйлдвэртэй харилцаа холбоо тогтоон ажиллахаар шийдээд байгаа болно. Ингэснээр шуудайны үндсэн түүхий эд болох РР-г гарган авсанаар шуудай үйлдвэрлэх бүрэн боломжтой болоод байна.



Зураг 7 Бүрэн автомат хогны уут наах машин






Зураг 8 Бүрэн автомат хогны уут наах машин

1.8. Технологийн процесс

2012 онд БНХАУ-ын дахивар бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Locomotive компанитай хийсэн гэрээний дагуу PP, PE, LLDF боловсруулах иж бүрэн шугам үйлдвэр оруулж ирсэн. Үйлдвэрийн технологийн процесс нь үндсэн 2 үе шатыг дамжина. Эхний үе нь дахивар бүтээгдэхүүнийг бэлтгэх, хоёр дахь үе нь багцын уутыг үйлдвэрлэх гэсэн үе шатыг дамжина. Дахивар бүтээгдэхүүнийг бэлтгэх үе нь 4 шатыг дамжиж, түүхий эдийн бүтээгдэхүүнийн бэлэн болгоно. Үүнд:

Хүснэгт 4. Технологийн эхний үе шат

№	Үе шат	Хийгдэх үндсэн ажил	Дамжлага үе шатыг зургаар
1	Түүхий бэлтгэн нийлүүлэгчдээс дахиварыг хуримтлуулах.	Гэрээт компани түүхий эдийг тээвэрлэн авчрана	

2	Дахивар бүтээгдэхүүнийг ангилан ялгах.	Түүхий эдээс үндсэн материал, туслах материал буюу доторлогоо, утас зэргийг ялгах	
3	Дахивар бүтээгдэхийг угаах, хатаах.	Бохирдлыг угаах	
4	Дахивар бүтээгдэхүүнээр түүхий эд болох мөхлөг бэлтгэх	Буталсан түүхий эд буюу РР (polypropylene) гаргаж авах	

Багцын уутыг үйлдвэрлэх шат дамжлага. Багцын уут үйлдвэрлэх үйл ажиллагаа үндсэн 2 үе шатаас бүрдэнэ. Үүнд:

1. Төхөөрөмжийг ажлын бэлэн байдалд бэлтгэх: халаагч теннүүд, халаагч теннүүдийг хөргөх сэнс, агаар хувиарлагч, уут хөөлгөх сэнс, соронзон редуктор бүхий хөдөлгүүр, хальс хувиарлагч хутга зэргийг шалгах.
2. Хальсыг үлээж ороогч төхөөрөмжинд холбох: Түүхий эд тэжээлийн хоргонд дүүртэл хийх /хийхийн өмнө элдэв механик хольцтой эсэхийг шалгах/, теннүүдийг хөргөлтийн сэнсний хамт асаах, хөөргөлтийн сэнсийг асаах, улмаар урд хөтлөгчтэй хальс хувиарлагчтай холбох.

Ажлын явцыг үе шатаар үзүүлвэл: /Зураг а, б, в, г/

Багцын уут үлэх процесс



Зураг 9. Багцын уутын тоног төхөөрөмжүүд

Технологийн шат дамжлагад түүхий эдийг шатаах ажил хийгддэггүй учир агаар орчныг бохирдуулах сөрөг нөлөөлөл бага боловч халааж бутлах, хэвлэх явцад хорт утаа агаар орчныг бохирдуулдаг.

1.9. Бэлэн бүтээгдэхүүн

Дахивар бүтээгдэхүүнээс гарган авсан түүхий эдээр компани нь зах зээл дээр 5 төрлийн хэмжээ бүхий хогны уут гаргасан ба мөн багцын уут үйлдвэрлэж байгаа болно /зураг. 26,27/. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Алтан тариа ХХК, Баясах Фүүдс ХХК, Дөрвөн Өлзий ХХК, ГБТ Трейдинг ХХК, Улаанбаатар гурил ХХК, Хөгжил Трэйд ХХК тай байгуулсан гэрээний дагуу нийлүүлдэг.



Зураг 10 Хогны уут болон багцлагч хальс



Зураг 11 Бэлэн бүтээгдэхүүн

1.10. Үйлдвэрийн усан хангамж

Үйлдвэрийн технологийн (хаягдал гялгар уутыг угаах, хөргөх) хэрэгцээнд сард 14м³ буюу 5 тн ус ашиглах ба 5 тн усыг 1 удаад тунгааж давтан ашигладаг мөн ууршилт болон бусад хаягдлаар хаягдахыг тооцож, жилд 2123 м³ буюу 750 тн ус шаардлагатай гэж үзэв. Энэхүү хэрэгцээт усыг үйлдвэрийн хашаанд гаргасан гүний худгаас авч ашигладаг. Нийт ахуйн хэрэгцээнд ашиглах усны хэмжээ сард 1.5 м³ жилд 648 м³ цэвэр ус ашиглахаар байна. Үүнээс ундны усыг савласан цэвэр усаар хангадаг. Ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг хянах стандарт MNS 4943 : 2015 шаардлагад нийцүүлэх шаардлагатай. Ахуйн хаягдал усны хэмжээг үйлдвэрийн нийт 20-30 ажилчдын ахуйн хэрэглээнд ашиглах усны нормоор /БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 тоот тушаал, “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”-ын Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр 80л/хоног/хүн/, технологийн хаягдал усыг нийт технологийн зориулалтаар ашиглах усаар тооцно. Хаягдал усны

шинжилгээгээр түүнд агуулагдах зарим ус бохирдуулагч бодис Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандартаас давсан тохиолдолд бохирдол үүснэ гэж үздэг. Гэвч технологийн процесст хөргөх зориулалтаар ус ашиглах үүнийгээ эргэлтэнд оруулж дахин ашигладаг, ахуйн хэрэглээнд (ажилчдын хувийн ариун цэвэр болон гал тогооны угаалга цэвэрлэгээннэс үүсэх) ус ашиглах учир ус бохирдуулсны төлбөр төлөхгүй, УСУГ-тай гэрээний дагуу цэвэр болон хаягдал усны төлбөр төлдөг.

1.11. Уурхайн цахилгаан хангамж

Үйлдвэрт цагт 80.6кВт, агуулахад 45кВт, нийлбэрээр 1 цагт 125.6кВт цахилгаан эрчим хүч хэрэглэхээр байна. Иймд үйлдвэрийн болон агуулахын цахилгаан хангамжийн эх үүсвэрийг 200кВт хэрэглэгч хооронд 0.4кВт-ын агаарын шугамаар холбон эцсийн шонгоос цахилгаан хэрэглэгчид нь ШРПС3х1 кабелиар тэжээгдэж байхаар төсөлд тусгасан байна.

1.12. Дулаан хангамж

Дулаан хангамжийг үйлдвэрийн бага оврын уурын зуухаар халаадаг. Галлагааны зууханд түүхий нүүрс түлдэггүй мөн зөвхөн өвлийн улиралд галлагаа хийдэг. Хуванцар савыг хайлуулах тоног төхөөрөмжүүд нь дулаан ихээр ялгаруулдаг тул үйлдвэрийг үргэлж галлагаа хийж халаагаад байдаггүй.

1.13. Завсрын бүтээгдэхүүн, Хог хаягдлын тооцоо

Үйлдвэрийн байрыг засаж сэлбэх, агуулах, зам, талбай барих ажлуудыг хийх ба барилгын материалын үлдэгдэл болон ажилчдын ахуйн хэрэглээний хатуу хог хаягдал зэрэг бий болно. Барилгын материалын үлдэгдэл хог хаягдлыг сардаа 2 удаа зөөн тээвэрлэх шаардлагатай. Барилгын ажлын үед доорх нэр төрлийн хог хаягдал үүснэ. Үүнд:

- Чулуу, шороо, элс, шавар зэрэг органик хог хаягдал
- Тоосго, цемент, цонхны шил, төмөр, шохой гэх мэт барилгын материалын үлдэгдэл
- Модон хаягдал
- Бусад

Ахуйн хаягдал: Үйлдвэрт нэг ээлжинд 10 хүн ажиллана гэж үзвэл: Нийт $10 \text{ хүн} * 0,3 \text{ кг/хоногт} = 3 \text{ кг/хоногт}$, жилд ойролцоогоор 900 кг хатуу хог хаягдал гаргахаар байна. /Барилгын хог хаягдлыг энд тооцоолон гаргах боломжгүй ба төслийн эхэн үед гарна./ Ахуйн хүрээнд доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гаргахаар байна. Үүнд:

- Хүнсний зүйлийн сав,баглаа,боодол
- Бие засах газрын хаягдал
- Полиэтилен уут,баглаа,боодол
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Тус компани нь төслийг хэрэгжүүлэх явцдаа хатуу хог хаягдлыг зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдлын цэгийг зонхилох салхиний доод талд битүү тагтай зориулалтын саванд хадгалах ба байгууламжаас 60 м-с багагүй зайтай байрлуулах ёстой.

- Төсөл хэрэгжих үеийн шингэн хаягдлын эх үүсвэр нь:
- Хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус
- Цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус
- Ариун цэврийн өрөөнүүдээс гарах бохир ус зэрэг болно.


Төслийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх цэвэр ус, ялгаран гарах шингэн хаягдлын тооцоо *Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 14 дүгээр хавсралтан дээр үндэслэн тооцов.* Төслийн хүрээнд 1 ээлжийн ажилчид нийлээд 10 хүн тогтмол байхаар тооцов: $(10 \text{ хүн} * 180 \text{ л/хоног} * 360 \text{ өдөр}) / 1000 = 648 \text{ м}^3 / \text{жилд}$ шаардлагатай усны хэмжээ/ Нийт хэрэглэх усны хэмжээ 1 жилд 648 м^3 цэвэр ус ашиглахаар байна. Үүний 70% буюу $453 \text{ м}^3 / \text{жилд}$ шингэн хаягдал гарах тооцоотой байна./ Технологийн хэрэгцээнд сард 5 тн ус ашиглах ба жилд 1500 тн ус ашиглана. Цаашид хаягдал усыг дахин ашиглах, цэвэршүүлэх чиглэлээр ажиллах шаардлагатай. Тус үйлдвэрийн хувьд хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл бохир усны цооног, хуванцар сав хайлуулах үеийн хий, утаа, автомашины утаа, галлагаатай зуухнаас ялгарах утаа зэрэг байхаар байна. Эдгээрээс хамгийн их байгальд нөлөөлөх хүчин зүйл нь хуванцар сав хайлуулах үеийн хий, утаа (7-р бүлгээс харна уу), хөдөлгөөнт эх үүсвэр болох автомашины утаа, галлагаатай зуухнаас ялгарах утаа зэрэг болно. Тус үйлдвэр нь автомашины хувьд

- Жип автомашин 1 (дизель хөдөлгүүртэй)
- Микро автобус 1 (дизель хөдөлгүүртэй)
- Бага оврын ачааны машин 1 (дизель хөдөлгүүртэй)

Тус үйлдвэр нь жилийн 4 улиралд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн тул галлагаатай зуухнаас агаар орчинд үзүүлэх нөлөө хүйтний улиралд нэмэгдэх болно.

1.14. Ариун цэврийн байгууламж

Үйлдвэрийн байр дотор стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж болох халуун усны шүршүүр болон суултууртай. Бохирыг тогтмол хугацаанд байгууллага болон хувь хүний автомашинаар соруулж, зайлуулдаг.



Зураг 12. Ариун цэврийн байгууламж

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Хатуу болон шингэн хаягдлаас хөрсөн бүрхэвч, гадаргын ус бохирдох цаашлаад ургамлан бүрхэвч амьтны аймагт дам нөлөөлөхөөр байна.
- Технологийн хэрэгцээнд ашиглах ус нь их биш боловч хэрэглээг зөв зохион байгуулаагүйгээс сөрөг нөлөөлөл үүснэ.
- Шингэн хаягдал ил задгай шүүгдэж, цэвэрлэгдэхгүй хаявал гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Технологи үйл явцаа зөв зохион байгуулахгүй бол байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөлөх өндөр байх магадлалтай.
- Технологийн шат дамжлагад түүхий эдийг шатаах ажил хийгддэггүй учир агаар орчныг бохирдуулах сөрөг нөлөөлөл бага боловч халааж бутлах, хэвлэх явцад хорт утаа агаар орчныг бохирдуулдаг.

Дээр өгүүлснээс дүгнэлт хийхэд байгаль орчинд сөрөг нөлөөлөл бага эрчимтэйгээр нөлөөлөх төслийн ангилалд багтах юм. Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, гадаргын ус, агаарын чанар байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурьдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй. Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	2	3	4	5	6
1	Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, хатуу хог хаягдал, угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, хөрсний ус	Сард 3 тн ус	Их	Төслийн туршид
2	Хорт хий, утаа	Байгаль орчны бүхий бүрэлдэхүүн хэсэгт	3.5 га	Дунд	Төслийн туршид
3	Технологийн хэрэгцээнд усыг замбраагүй ашиглах	Гүний худаг	Сард 5 тн	Их	Төслийн туршид
4	Хорооны иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл алдагдах	Ажилтан, хорооны иргэд	500 м радиус доторх 5 айл	Дунд	Тогтоох боломжгүй

Үйлдвэрийн технологийн онцлог, хүчин чадалд тохирох агаар цэвэршүүлэгч байршуулах, талбайг хатуу хучилттай болгох, ногоон байгууламж барих, үйлдвэрийн нэн шаардлагатай туслах байгууламжийг барьж байгуулах. Хуванцар материалыг халаахад хортой хий буюу акрилын хүчил, Ацетон, Бутадиен, Бутан, Формальдегид, Альдегид, Устөрөгчийн хлорид, Устөрөгчийн цианид, Фенол зэрэг бодис ялгардаг. Дээрхи хорт бодис бүхий орчинд удаан ажиллах нь зүрхний шигдээс, амьсгалын замын өвчлөл, харшил, мэдэрлийн систем гэмтэх, цаашлаад дотоод эд эрхтэн гэмтэх, өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Мөн хүрээлэн буй орчны бүрэлдэхүүн хэсэгт удаан хугацаагаар хадгалагдаж үлддэг. Энэ төрлийн бодисоор хордсон амьтдын үржил буурах, дархлалын систем гэмтэх зэрэг эрсдэлд өртдөг.

Нөлөөллийн цар хүрээг хорооны иргэдээс авсан асуулга, бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хэмжилтийн дүн, салхины чиглэл зэргийг харгалзан тогтоов. Ингэхэд хорт утаа буюу хий нь үйлдвэрээс 100 м зайд нөлөөлөх буюу хүнийг хордуулах өндөр нягтшилтай байх ба 100 метрээс цааш саармагжих боловч хотын агаарын бохирдолд тодорхой хэмжээний нөлөө үзүүлэхээр байна.



Зураг 13. Хорт хий, утааны нөлөөллийн цар хүрээ

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А№117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь: 1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө 2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэн

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОМТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Пластик Саксес” ХХК” заавал

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОМТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай

БОМТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх, БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх ёстой. БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх нийт зардалд урьдчилсан байдлаар 4 сая 930 мянган төгрөг төсөвлөв.

Хүснэгт 6. БОМТ-ийн зардлын задаргаа

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2023 оны зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	410000
3	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1750000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1000000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	270000
6	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулах	1500000
7	БОМТ-н хэрэгжилтийг тайлагнах	-
	Нийт	4930000

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх зардал, мян.төг	Хамрах хүрээ, Хариуцах эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					
Шуудайг шатаах явцад утаа агаар орчныг бохирдуулна.	Үйлдвэрээс утааг соруулан гадаад орчинд хаях ба агааржуулалтын хоолойд шүүлтүүр байршуулах	100.0*4=400.000	Үйлдвэрийн орчинд, ХАБЭА инженер	2023 1,7-р сард	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5480:2014 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
Ногоон байгууламж хүний болон техник хэрэгсэлийн хөдөлгөөний улмаас устах, эвдэрсэн талбайгаас тоосжилт үүсэх			Үйлдвэрийн орчинд, ХАБЭА инженер	2023 6-р сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5480:2014
Хөрс болон ургамлан бүрхэвч					
Үерийн усаар үйлдвэрийн талбай угаагдаж үйлдвэрийн хог хаягдал, шатах тослох материалаар хөрсөн бүрхэвч бохирдох аюул байгаа тул суваг шуудуу татах	Далан, хамгаалалт, ус зайлуулах суваг зэргийг иж бүрэн хийх шаардлагатай. Ингэснээр гадаргын ус хөрсөн бүрхэвч бохирдохоос урьдчилан сэргийлнэ.	-ҮА зардалд	Байгууллагын удирдлага ХАБЭА инженер	2023 10-р сард	Монгол улсын барилгын норм ба дүрэм
Технологийн үе шатанд түүхий эдийг халаахад үүссэн утаа Үйлдвэрийн дотоод орчныг болон агаарт хаягдаж ажилчид болон иргэдийг хордуулна.	Халаалтын зуухны эх үүсвэр, агааржуулалтын хоолой орчимд утаа мэдрэгч байршуулах	-ҮА зардалд	ХАБЭА инженер	2023 3-р сард	Агаарын тухай хууль

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гадаргын болон гүний ус					
Борооны усыг хөргөлтийн системд ашиглах боломжийг судлах	Засвар үйлчилгээ, үзлэгийг тогтмол хийх	- ҮА зардалд	ХАБЭА инженер Үйлдвэрийн дарга	2023 3-р сараас эхлэн сар бүр	“Усны тухай” хуулийн 33-р зүйл 33.1.14 ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг тогтмол төлж байх	Цэвэр усны ашиглалт багасна. Зөв зохистой ашиглана.	- ҮА зардалд	Байгууллагын удирдлага	2023 1-р сараас эхлэн сар бүр	“Усны тухай” хуулийн 33-р зүйл 33.1.14
Гүний усны хомсдол	Ахуйн усны хэрэглээг тооцох, хэмнэлттэй зарцуулах, ажлыг зохион байгуулах жишээ нь: ус хэмнэгч хошууг бүх тосгуурт байршуулах, тогны хүчдэл хэмнэх сүүн гэрлээр үйлдвэрийн гэрлүүдийг солих	- ҮА зардалд	Байгууллагын удирдлага	2023 5-р сараас эхлэн сар бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Дүнжингарав худалдааны төв 275-р лангуу
Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй					
Үйлдвэрийн дотоод орчны чийглэг, дуу чимээ, тоос, хорт хийгээ зэргээс ажилчид хордох	Агааржуулалтын системийг сайжруулах, хамгаалах хувцас хэрэгслийг нормын дагуу олгох	- ҮА зардалд	Байгууллагын удирдлага ХАБЭА инженер	2023 1-р сараас эхлэн сар бүр	ХАБЭА тухай хууль
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, автомат мэдрэгч, унтраалгын систем суурилуулах	- ҮА зардалд	ХАБЭА инженер	2023 онд	ХАБЭА тухай хууль
Цар тахалын үед ажилчид болон бараа бүтээгдэхүүний гадаргуугаар халдвар тархах	Гар ариутгагч, халуун шалгах төхөөрөмж суурилуулах, анхан шатны тусламж үзүүлэх хайрцаг, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц	- ҮА зардалд	ХАБЭА инженер	2023 онд	Эрүүл мэндийн тухай Гамшгаас хамгаалах тухай АЖЛЫН БАЙРАНД КОРОНАВИРУСЫН /COVID-19/ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах шаардлагатай.				ажиллах МУ-ын ШС-ын 149 тогтоол
	Нийт: 410.000				

**ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг үйлдвэрийн дарга болон технологийн мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Урьдчилан тооцсон төсөв, хуваарь, мян.төг	Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт
1	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг /хог хаягдлыг багасгах сэдвээр/ жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны мэргэжилтэн, НМХГ байцаагч нартай харилцан холбоотой ажиллах	2-р сард	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 БОНБУ тухай хууль
2	Дүүргин онцгой байдлын газраас галын аюулгүй байдлын дүгнэлт авах, хамтарсан дадлага сургуулилт хийх	Гал унтраагуур ашиглах-80.000, 4-р сард	Дүүргийн онцгой байдлын газар
4	Байгаль орчны аудит хийлгэх, өргөтгөл хийсэн тохиолдолд үнэлгээний тайланд тодотгол хийлгэх	1.500.000	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
5	Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэх	-	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл
6	Халдваргүйжүүлэлт, шавж устгал, мэрэгч устгал хийлгэх	-	Хувийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх MNS5161;2002
7	Байгаль орчин аялал жуулчлалын яаманд дараагийн жилийн БОМТөлөвлөгөөг хянуулах, хэлэлцүүлэх, батлуулах	12 сарын 1- ний дотор	БОАЖСайдын 2019 оны А-618 дугаар журмын дагуу
8	Нийслэлийн байгаль орчны газарт БОМТ, биелэлтийн тайланг дүгнүүлэх	11 сарын 1- ний дотор	
9	Дагаж мөрдөх хууль, дүрэм, журмын жагсаалт гаргаж, улирал бүр эдгээр дүрэм, журам, стандартын шаардлагыг хэрхэн	2-р сараас эхлэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, олон улсын байгаль орчин, хөдөлөрийн аюулгүй

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	биелүүлж ажиллаж байгааг гаргах, шинэчлэгдсэн заалтыг тусгаж байх зохицуулалтын журам (хуулийн нийцлийн) гаргаж, мөрдөх		ажиллагааны менежментийн тогтолцооны стандарт
10	Үйлдвэрийн хашаанд болон орчны бүсэд (500м зайд) хавар, намрын их цэвэрлэгээ хийх	5, 10 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
11	* Дэлхийн усны өдөрт зориулж байгаль орчныг хамгаалах чиглэлийн байгууллагуудтай хамтран ажиллах	3-р сарын 22	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Нийт	1.500.000	

ДОЛОО. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлт ийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
Тэр бум модны хүрээнд мод тарих үндэсний өдөр ногоон байгууламж хийх, мод тарих	Үйлдвэрийн хашаа	Зүлэг, цэцгийн мандал тарих /үрээр, суулгацаар/	м 2	370 м2	250 000₮/жил болгон/	250 000* =1 250 000₮
		Хар шороо	тн	3	300 000₮	500 000₮
	Үйлдвэрийн хашаанд мод тарих талбай байхгүй тул Дорноговь аймгийн Эрдэнэ сум	2021 онд Дорноговь аймгийн Эрдэнэ суманд “Шамбала-2056” төсөлтэй хамтарч цөлжилтийн эсрэг 50 ширхэг модыг 1.750.000 төгрөгөөр тарьсан ба 2023 онд тарьсан модыг шалгах, мөн мөнгөн дүнгээр суулгац тухайн газраас авч суулгах				
Хашаа дагаж байршуулсан ногоон байгууламжийг хашаа хайс хийж хамгаалах	Үйлдвэрийн хашаа	Өөрийн үйлдвэрээс гарах түүхий эдийг ашиглах				
Нийт зардал						1.750.000₮

НАЙМ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаяглын ангилал, Болзошгүй сөрөг нөлөөлөл	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хамрах хүрээ, Хариуца х эзэн	Зарцуулагдах зардал мян.төг	Дагаж мөрдөх журам, арга аргачлал	Хугацаа
Ахуйн хог хаягдал ил задгай хаягдах	Хоёрдогч түүхий эдийг үйлдвэрлэх төсөл учир хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах, үүсэхээс урьдчилан чиглэлийн ажлыг санаачлах, турших ажлыг хийж, олон нийтэд мэдээлэх		1.000.000		2023.04.01
Хүний эрүүл мэндэд нөлөөлнө. Үүнд: Сүрьеэ, гэдэсний халдварт өвчин, боом, татран зэрэг өвчин тархах нөхцөл бүрдэнэ.	Хатуу хог хаягдлыг ангилан 2 догч түүхий эд авах газарт хүргэх. Жишээ нь аккумулятор, хуруу зай, машины дугуй, хуванцар сав	ХАБЭА ажилтан	-	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга	Авто машины дугуйг резинэн хавтан үйлдвэрлэдэг компанид өгөх. www.mongolrubber.mn

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

БОМТ-г хэлэлцүүлэх оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Агуулга	Хугацаа	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Хорооны иргэд, НБОГ-т биелэлтийн дайлан дүгнүүлэх, БОАЖЯ-д тухайн жилийн	Хороны иргэдийн төлөөлөлийг үйлдвэрийн	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг	10-р сард	Сөрөг нөлөөллийг бууруулах талаар санал	Компанийн байранд

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

төлөвлөгөөг батлуулах тухай удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэсэгт тусгасан	талбайд хүлээн авах	нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил		авах, шинэлэг санал, санаачлага	
---	------------------------	---	--	---------------------------------------	--

АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) “Пластик Саксес” ХХК-ийн БГД-н 14-р хорооны нутагт хэрэгжих “Хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах үйлдвэр” төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан юм. ОХШХ нь БОМТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгалаа. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулна. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин аялал жуулчлалын яам /-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллана. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Пластик Саксес” ХХК хариуцах болно.

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Баримтлах стандарт аргачлал
Агаарын чанар							
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр болох агаарын чанарын бүх үзүүлэлтээр хянах /жишээ нь PM 10, TSP, SO ₂ , NO ₂ , CO г.м/	Мг/м ³	Үйлдвэрийн дотоод орчинд	Жилд 1	Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэрийг хяналтын хэмжих горимоор хийх	45*2	90000	Дээжлэхдээ MNS 4585:1998, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
Ажлын байрны агаарын найрлага, тоосжилт чийгшил, дуу чимээг хэмжих арга хэмжээ авах	Мг/м ³	Ажлын байранд	Жилд 1	Ажлын байранд эрүүл ахуйн хэмжилт шинжилгээ хийх	30	30000	MNS(ISO) 4227:2002 MNS 5585:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага MNS 5002:2000
Хөрс							
Хөрсний бохирдол, хүнд металл ялзмагийн агууламж, рН, давжилт, чийгшил, NO ₃ -N, P ₂ O ₅ , K ₂ O, рН, нийт азот, нийт фосфор	%, dS/m, мг/100г, см,	Хогийн цэг 2020,2021,2022 оны дээж авсан цэгт	Жилд 1	Хөрсний хяналт шинжилгээг хөрсний дээж авах стандартыг баримтлан авах	Агрохими-25, хүнд метал-25	50000	MNS:3297:1991 “Ариун цэврийн тухай” хууль:7-р зүйл: 7.4, 7.5 MNS 3473:1983 MNS 3297:1991 MNS 4288:1995
Усан орчин							
Гэдэсний бүлгийн нян, салмонел, Кальци, магни, аммони, нийт төмөр гм	Мг/л м ³	Ундны усны эх үүсвэрт	Жилд нэг удаа	Ахуйн болон технологийн хэрэглээний усанд тохирох эсэхийг шалгах	50.0	50000	MNS 9308:1998 MNS 19250:2017 MNS 4496:1997
Усны ерөнхий шинжилгээ	Мг/л м ³	Бохир усанд	Жилд нэг удаа	Дахин цэвэршүүлэх, шүүх шаардлагатай эсэхийг хянах	50.0	50000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт зарцуулах /урьдчилсан байдлаар/ тооцсон зардал					270.000.0		

